



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 2/67

Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн спортын VI наадмын хаалтын ажиллагааны тайз, карказ, нэвтрүүлгийн зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн Иргэдийн спортын VI наадмын шигшээ тэмцээн зохион байгуулахад шаардагдах тайз, карказ, гэрэлтүүлэг чимэглэлийг түрээслүүлэхийг “Неон шоу” ХХК-тай, тус наадмыг сурвалжилж, 30 минутын нэвтрүүлэг бэлдэж, телевизийн эфирээр олон нийтэд хүргэхийг “Дабль бат медиа” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хариуцуулж, бэлтгэл ажлыг сайтар хангаж тэмцээнийг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга /А.Болдмаа/-д даалгасугай.

2. Нийслэлийн Иргэдийн спортын VI наадмын шигшээ тэмцээн зохион байгуулах бэлтгэл ажлуудыг хангахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Нийслэлийн Иргэдийн спортын VI наадмын шигшээ тэмцээн зохион байгуулах бэлтгэл ажлуудыг хангахад шаардагдах 1.557.500 /нэг сая таван зуун тавин долоон мянга таван зуун/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Дээрх бэлтгэл ажлуудыг чанартай хийж гүйцэтгүүлэхийг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2017 оны *11* сарын *23*-ны өдрийн *167* дугаар тушаалын хавсралт



Нийслэлийн иргэдийн спортын VI наадмын нээлт, хаалтын ажиллагааны тайз, карказ, гэрэлтүүлгийн түрээс, нэвтрүүлгийн зардлын төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тайз, карказ /2 өдөр х 328.750 төг/	657.500
2.	Гэрэлтүүлэг түрээс /2 өдөр х 10ш х 20000 төг/	400.000
3.	Нэвтрүүлэг бэлтгэж, эфирээр цацах	500.000
ДҮН:		1.557.500

Боловсруулсан:

Н.Өлзийжаргал

Хянасан:

О.Эрдэнэцэцэг